



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 09 сарын 24 өдөр

Дугаар 12

Арвайхээр

Ажлын хэсэг байгуулах тухай

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх ороход мэргэшлийн шалгалт авах журам”-ын 5.6, 5.7.1, 6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалтын бэлтгэлийг хангуулах, бүртгэлийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: -Э.Бадамгэрэл аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга

Гишүүд: -П.Мөнхзул аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

-Ц.Удвал аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

-Р.Наранцэцэг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн

-Л.Ишханд аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн

-Б.Занданшарав аймгийн Засаг даргын Тамгын газрын Компьютер, техник хангамжийн засвар үйлчилгээ хариуцсан ажилтан

2. Мэргэшлийн шалгалтад анх орох иргэний бүртгэлийн холбогдох материалыг хүлээн авч, нягтлан шалгах, мэргэшлийн шалгалтын бүртгэлийг цахимаар хийх, компьютер, интернэтийн сүлжээ, эрчим хүчний найдвартай байдлыг бий болгож, шалгалт авах байрны бэлтгэл, шалгалт зохион байгуулах хэвийн нөхцөл байдлыг ханган ажиллахыг ажлын хэсэг (Э.Бадамгэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ГАНБОЛД

013100023

D: My Doc. Tushaal. ZDTG